



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй, 21 нэрийн, нийт 186,379,668.38 (нэг зуун наян зургаан сая гурван зуун далан есөн мянга зургаан зуун жаран найман төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 135,193,853.75 (нэг зуун гучин таван сая нэг зуун ерэн гурван мянга найман зуун тавин гурван төгрөг далан таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Гансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001316
12-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025-оны... дугаар сарын 10-ны өдрийн
478 дугаар тогтоолын хавсралт

"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨААТУГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ.
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
	Барилга, байгууламж							
1	Гадна холбооны шугам	2003-01-01	м	4000	5,250.00	21,000,000.00	17,532,831.93	3,467,168.07
2	Дулаан, цэвэр усны шугам /орон сууц/	2015-12-24	м	50	507,241.82	25,362,090.91	7,690,290.98	17,671,799.93
	Дүн			2	512,491.82	46,362,090.91	25,223,122.91	21,138,968.00
	Тээврийн хэрэгсэл							
3	Автобус, микро автобус, 60-39 ДГО, KMJWAN7JP9U144251	2013-01-24	ширхэг	1	29,517,095.45	29,517,095.45	29,517,095.45	-
	Дүн			1	29,517,095.45	29,517,095.45	29,517,095.45	-
	Машин, тоног төхөөрөмж							
4	Тог баригч	2016-12-20	ширхэг	1	40,365,000.00	40,365,000.00	29,745,429.10	10,619,570.90
5	Цохилттой дрилл	2017-12-20	ширхэг	1	325,000.00	325,000.00	325,000.00	-
6	Гар станц Telt N60	2021-05-13	ширхэг	7	153,636.37	1,075,454.56	1,075,454.56	-
7	Гар утас /хар, андройд/	2021-06-14	ширхэг	1	494,000.00	494,000.00	460,158.30	33,841.70
8	Хяналтын камер	2014-09-10	ширхэг	1	11,000,000.00	11,000,000.00	9,570,764.48	1,429,235.52
9	Хяналтын камерын дамжуулагч антенн 5гц	2022-12-19	ширхэг	8	550,000.00	4,400,000.00	1,057,533.44	3,342,466.56
10	Даралт хэмжигч	2016-12-20	ширхэг	1	4,200,000.00	4,200,000.00	773,655.22	3,426,344.78
11	Тусгай зориулалтын нөүтбүүк	2014-04-18	ширхэг	1	2,723,500.00	2,723,500.00	2,723,500.00	-
	Дүн			21	59,811,136.37	64,582,954.56	45,731,495.10	18,851,459.46
	Тавилга, эд хогшил							
12	Байгууллагын хаяг /цэнхэр/	2017-12-21	ширхэг	1	2,470,000.00	2,470,000.00	2,352,460.90	117,539.10
13	Гадна хаяг /лаборатори цагаан,гэрэлтэй/	2022-10-01	ширхэг	1	1,145,454.55	1,145,454.55	298,832.21	846,622.34

№	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
14	Гадна хаяг /байгууламж, цагаан гэрэлтэй/	2022-10-01	ширхэг	1	1,766,909.09	1,766,909.09	460,956.57	1,305,952.52
15	Гадна хаягжуулалт /сав, хашааны/	2023-01-30	ширхэг	1	7,818,181.82	7,818,181.82	1,851,281.65	5,966,900.17
16	Шүүгээ шилтэй саарал	2002-12-31	ширхэг	1	114,582.00	114,582.00	109,133.10	5,448.90
17	Уулзалтын ширээ	2002-12-31	ширхэг	1	101,400.00	101,400.00	96,574.50	4,825.50
18	ДДЭШ ТВ	2016-11-11	ширхэг	1	180,000.00	180,000.00	152,148.54	27,851.46
19	ДДЭШ	2017-12-21	ширхэг	1	221,000.00	221,000.00	210,481.10	10,518.90
	Дүн			8	13,817,527.46	13,817,527.46	5,531,868.57	8,285,658.89
	Биет бус хөрөнгө /програм хангамж/							
20	Байгаль орчины нарийвчилсан үнэлгээ	2016-03-18	ширхэг	1	16,500,000.00	16,500,000.00	15,046,530.82	1,453,469.18
21	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг	2016-12-14	ширхэг	1	15,600,000.00	15,600,000.00	14,143,740.90	1,456,259.10
	Дүн			2	32,100,000.00	32,100,000.00	29,190,271.72	2,909,728.28
	НИЙТ ДҮН			34	186,379,668.38 (нэг зуун наян зургаан сая гурван зуун далан есөн мянга зургаан зуун жаран найман төгрөг гучин найман мөнгө)	135,193,853.75 (нэг зуун гучин таван сая нэг зуун ерэн гурван мянга найман зуун тавин гурван төгрөг далан таван мөнгө)	51,185,814.63 (тавин нэгэн сая нэг зуун наян таван мянга найман зуун арван дөрвөн төгрөг жаран гурван мөнгө)	